



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/350

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймагт зохион байгуулсан “Алтай бидний нийтийн гэр” Олон улсын зохицуулах зөвлөлийн 15 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Оросын Холбооны улсын Алтайн хязгаарын Белокуриха, Смоленск мужид зохион байгуулагдах “Их Алтай. Россия-2019” олон улсын тамирчид, залуучуудыг хамарсан спорт, аялал жуулчлалын их наадамд аймгаа төлөөлөн оролцох Ч.Сүхбаатар ахлагчтай 10 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдын зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5 000 000 төгрөг /таван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалт”-ийн 5.17 дахь “Спортын аварга” хөтөлбөрөөс гаргахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/350 Ch  
02 01738



Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар  
сарын 05 -ны өдрийн А/350 дугаар  
захирамжийн хавсралт

“ИХ АЛТАЙ. РОССИЯ-2019” ОЛОН УЛСЫН ТАМИРЧИД, ЗАЛУУЧУУДЫГ  
ХАМАРСАН СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ИХ НААДАМД ОРОЛЦОХ БАГ  
ТАМИРЧДЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Зардлын төрөл зүйл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Баг тамирчдын оролцох хураамж /100\$*10 хүн*2653₮/	ш	10	265.300	2 653.0
2	Шатахууны зардал /2 талдаа 2400км*18л*2135/	литр	430	2135	920.0
3	Жолоочийн хариуцлагын даатгал /Автобус ангилал 16 хүний суудалтай/	ш	1	127.000	127.0
4	Байр, хоолны зардлын дэмжлэг	ш	10	100.000	1 000.0
5	Эрүүл мэндийн даатгалын зардлын дэмжлэг	ш		30.000	300.0
	ДҮН				5 000.0

-oOo-